ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ ДУГААР

mminfo.mn Шударга, Шуурхай, Онцгой мэдээлэл

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,086.203... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.05.30. Даваа. №110 (4480) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

СЕХ МАХН-ЫНХНЫГ БҮРТГЭЖ, ХУУЛЬ ЗӨРЧИХ ҮҮ

II нүүрт

ДЭЛХИЙ

БАРАК ОБАМАГИЙН ТҮҮХЭН АЙЛЧЛАЛ

VII нүүрт

УЛСТӨРЧИЙН ХӨРӨГ



# ХЭМ ХЭМЖЭЭГ ТОГТООГЧ

Дэлгэрэнгүйг V нүүрнээс

ҮЗЭЛ БОДОЛ

## ӨНӨӨ ЖИЛИЙН СОНГУУЛИАР “ГАЛ ГАРСАН” ТУЛААН ӨРНҮҮЛЧИХ ӨРСӨЛДӨГЧИД АЛГА

–УИХ–ын сонгуульд нэр дэвшигчдээ улс төрийн намууд эцэслэн батлав–

Б.ӨНӨРТОГТОХ

Өнгөрөгч долоо хоногийн баасан гарагт улс төрийн намууд шөнө дөлөөр хуралдаж, 2016 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдээ батламжлав. Хуулийн хугацаа тухайн өдрийн 00.00 цагаар дуусгавар болж байсан учраас өглөөнөөс эхлэн МАН-ын удирдлагууд нэр дэвшихээр горилж байсан хүн нэг бүртэй уулзаж, улмаар намынхаа Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлсний дараа Бага хурлаар хэлэлцэж батламжилсан юм. Харин АН-ын тухайд даваа гарагаас эхлэн намынхаа анхан шатны нэгж хороодоор хэлэлцүүлж, улмаар ҮЗХ-ны хурлаар эцэслэн баталсан билээ. Гэвч дотоод дүрмийн дагуу анхан шатны нэгжээс дэмжлэг авсан ч ҮЗХ-ны хурлын үеэр бүдэрч, эсрэгээрээ анхан шатнаас дэмжлэг авч чадаагүй ч намынхаа хурлын үеэр дэмжлэг авах хүмүүс цөөнгүй байлаа.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




Дугаарын 60 мөр

## АСЕМ-ийн төлөөлөгчид аваад явчих биш дээ

Н.ПУНЦАГБОЛД

Энэ зун наадмын дараа АСЕМ-ийн уулзалт Монголд болох учиртай. Дэлхийн олон орны өндөр дээд албан тушаалтнууд, гадаадын сэтгүүлчид, зочид, төлөөлөгчид манай улсад ирж, хоёр гурав хоног бужигнах юм. Тиймээс монголчууд бид нэр нүүрээ бодож, Улаанбаатар хотынхоо өнгө үзэмжийг дээшлүүлэхээр чадах чинээгээрээ л ажиллаж байна. Хөрөнгө мөнгө ч багагүй зарж байгаа. АСЕМ-ийн уулзалтыг нэгэнт зохион байгуулахаар болчихсон юм чинь ажил хийвэл хийсэн шиг хийгээд, гадаадын олон зочдын өмнө нүүр улайхааргүй зохион байгуулаад л өнгөрөөчих хэрэгтэй шүү дээ. Гэтэл сонгууль дөхөж байгаатай холбогдуулаад АСЕМ-ийн зам, ардын зам ч гэх шиг хол явахгүй хар пиар хийж эхэллээ, зарим нэгэн нь.

Үргэлжлэл нь III нүүрт

## МЭДЭГДЭЛ

“Цензургүй яриа”, “Цензургүй сурвалжлага” нэвтрүүлгийн редактор, хөтлөгч сэтгүүлч Л.Мөнхбаясгаланг 2016 оны тавдугаар сарын 25- ны шөнө АНУ -ын Вашингтон хотод байрлах Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн холбоо руу ажлаар явах гэж байхад нь нислэгээс нь дөрвөн цагийн өмнө буюу оройн 20 цаг өнгөрч байхад Эрүүгийн Цагдаагийн газраас гэрээс нь дуудаж эрүүгийн хэрэг үүсгэн, сэжигтнээр татаж, улсын хилээр гарах эрхийг нь хассан үйл явдал боллоо. “Монголын өдөр тутмын сонинуудын холбоо” энэ үйл явдлыг сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад нь хөндлөнгөөс санаатайгаар саад учруулсан хэмээн үзэж эрс эсэргүүцэж байгаагаа үүгээр мэдэгдэж байна.

Сэтгүүлч Л.Мөнхбаясгалан Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн холбооны дэлхий нийтэд дэлгэсэн оффшор бүсэд хувьцаа эзэмшдэг улстөрчдийн тухай “Цензургүй сурвалжлага- Оффшор данс эзэмшигчдийн мөрөөр” хэмээх эхний нэвтрүүлгээ хийчихээд хоёр дахь нэвтрүүлгээ хийхээр Вашингтон нисэх гэж байхад ийм үйл явдал болсон нь өнөөдөр нийгэмд зэвүүцэл төрүүлж эхэллээ. Нийгэм эл үйлдлийг эсэргүүцэж байна.

Төрийн харъяатай хэвлэл мэдээллийг хувьчилж хувь хүний үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хуулиар олгосон 26 жилийн турш бүх сонин сэтгүүл, телевиз радио төрийн өмчит болон хувийн аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж санхүүжсээр ирсэн. Гэтэл сэтгүүлч Л.Мөнхбаясгаланд МИАТ компанитай 2013 онд байгуулсан зөвлөх үйлчилгээ үзүүлж хамтран ажиллах гэрээг нь залилангийн гэмт хэрэг хэмээн үзэж, Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.4-т заасан онц хүнд гэмт хэргийн санкцаар яллахаар завдаж буйг бид буруушааж байна. Учир нь Монголын бүх хэвлэл мэдээллийн байгууллагад иймэрхүү гэрээ өнгөрсөн 26 жилийн түүхэнд хэдэн зуун мянгаараа бий. Сэтгүүлчид өс санасан, түүний хурц үг, зоримог нэвтрүүлгээс айсан эрх бүхий албан тушаалтнууд хэн нэгэн сэтгүүлчийг “хашрааж шоронд хийе ” гэвэл иймэрхүү гэрээг хаанаас ч ухаж гаргаж ирж болох юм байна гэсэн сэрэмж төрж айдас төрүүллээ.

Л.Мөнхбаясгалан нь түүний өөрийнх нь хэлснээр өчигдөргүй сэтгүүлч биш ээ. Тэрбээр Монголын тогтмол хэвлэлийн орон зайд өөрийн гэсэн тодотголтой улстөр, эрэн сурвалжлах чиглэлээр дагнан бичиж амжилт олсон шилдэг нийтлэлчдийн нэг гэдгийг уншигчид мэднэ. Тэр амьдралынхаа 17 жилийг сонины гал тогоонд ажиллаж өнгөрүүлсэн бөгөөд Монголын өдөр тутмын сонинуудын холбооны гүйцэтгэх захирал бөгөөд, мөн “Улс төрийн тойм” сониныг үүсгэн байгуулж хөл дээр нь босгосон сэтгүүлч юм. Тэрбээр нийгмийн сайн сайхны үйлсэд хоёргүй сэтгэлээр зүтгэдэг бөгөөд өнгөрсөн жилийн 11 сард “Цензургүй яриа хавдрын эсрэг” аяныг өрнүүлж, ХСҮТ-ийн таван жил гацаж хүлээгдэж байсан өргөтгөлийг бариулах болон тус эмнэлэгт СТ -сити томаграффи аппаратыг авах 4,8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс шийдүүлж, саяхан ХСҮТ-д хавдартай өвчтөнд элэг шилжүүлэн суулгах мэс заслыг Монголдоо хийлгэж нутагшуулахын төлөө дутагдаж байсан тэрбум төгрөгийг өөрийн нөхдийн хамт хөөцөлдөж, НИТХ -аас шийдүүлсэн зэрэг ажлуудыг хийсэн билээ.

Монголын Өдөр тутмын сонинуудын холбоо сэтгүүлч Л.Мөнхбаясгаланд үүсгэсэн эрүүгийн хэрэг болон хилээр гарах эрхийг нь хаасан энэ хориг үйл явдлыг эрс эсэргүүцэж байгаагаа мэдэгдэж байна.

**Монголын өдөр тутмын сонинуудын холбоо**

**2016 оны тавдугаар сарын 30**

ӨДӨР ТУТМЫН СОНИНУУДЫН ХОЛБОО ТББ ӨДӨР ТУТМЫН СОНИНУУДЫН ХОЛБОО УЛААНБААТАР ХОТ ТТС1268 ☏ 1091131

ТОМИЛОЛТ

## БАЯНХОНГОР АЙМАГТ 77 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ ХИЙГДЖЭЭ

Н.БАТЗАЯА

Баянхонгор аймгийн Ардчилсан намын хороо энэ сарын 26-нд хуралдаж, нэр дэвшигчдээ тодруулллаа. 100 гаруй гишүүн оролцож, хаалттай хуралдсаны эцэст УИХ-ын гишүүн Х. Баттулга, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Олимпийн аварга Н.Түвшинбаяр, УИХ-ын гишүүн Д.Ганбат нарыг 100 хувийн санал нэгтэйгээр сонгосон юм. УИХ-ын гишүүн Х Баттулгын хувьд тус аймагт өмнө нь гурван удаа нэр дэвшиж байсан. Энэ удаад ч гэсэн намын нөхөд нь түүнийг тойрогтоо дахин сонгож, УИХ-д нэр дэвшүүлэхээр болсон. Харин Д.Ганбат гишүүний тухайд тус аймагт хоёр дахь удаагаа нэр дэвшиж буй бол Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Олимпийн аварга Н.Түвшинбаярын хувьд анх удаагаа нэр дэвшиж буй юм. Тэрбээр энэ тухайгаа ярихдаа “Баянхонгор нутгийнхан сайхан хүлээж авч байна. Би бодохдоо Булган аймгийн хүн хүрээд ирлээ гэх болов уу гэж бодсон. Гэтэл халуун дотно хүлээж авлаа. Миний амжилтууд Баянхонгор аймагтай нягт холбоотой явж байдаг учраас их бэлгэшээлтэй байдаг юм” гэв. Энэ үеэр УИХ-ын гишүүн Х.Баттулга түүнийг Монголын хүн хэмээн онцолсон.

Үргэлжлэл нь II нүүрт




ХААН банк

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1990.00 | 2004.00 | ФУНТ | 2879.00 | 2964.00 |
| ЕВРО | 2207.00 | 2260.00 | РУБЛЬ | 28.50 | 32.30 |
| ИЕН | 17.95 | 18.39 | ЮАНЬ | 302.00 | 305.50 |

Худалдаа хөгжлийн банк

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1992.00 | 2005.00 | ФУНТ | 2871.00 | 2978.00 |
| ЕВРО | 2186.00 | 2277.00 | РУБЛЬ | 28.41 | 32.74 |
| ИЕН | 17.79 | 18.61 | ЮАНЬ | 302.30 | 305.60 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

E-mail: mongoliin_medee@yahoo.com Утас: 976-70113551 Факс: 976-70113551

## УЛС ТӨР

ТОМИЛОЛТ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**



Ямартай ч, Баянхонгор аймгийн Ардчилсан намынхан хуулийн хугацаанаас өмнө гурван нэр дэвшигчээ ийнхүү тодруулав. Манай сурвалжлах хэсэг үргэлжлүүлэн Баянхонгор аймагт өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд хийгдсэн бүтээн байгуулалттай танилцлаа.

### Авто зам тавьж, нийтийн тээврийн асуудлыг шийджээ

Улаанбаатар хотоос Баянхонгор аймаг хүртэл 630 км. Энэ замыг туулах гэж хонон өнжин давхиж, дотор эрхтний байр солигдох нь холгүй энхэл, донхол замыг туулан очдог байсан нь билээ.

# БАЯНХОНГОР АЙМАГТ 77 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ ХИЙГДЖЭЭ

Гэвч одоо Улаанбаатараас говь, хангай хосолсон Монголын үзэсгэлэнт аймгуудын нэг болох Баянхонгорыг зорих зорчигчид хатуу хучилттай замаар долоон цагийн дотор л давхиад очих болж. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд Баянхонгор аймагт хийгдсэн томоохон бүтээн байгуулалтын нэг нь авто зам. Түүний тодорхой нэгэн жишээ нь улсын төсвийн 45 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар бүтсэн Баянхонгор Арвайхээр чиглэлийн 108.3 км авто зам ажээ. Уг замын ажлыг "Нэйшнл Девелопер" болон "Шинжиан Бэйшн роуд энд бридж констракшн" компаниуд хамтран хийж, 2013 оны наймдугаар сарын 28-нд хүлээлгэн өгснөөр ашиглалтад орсон аж. Мөн аймгийн төвдөө хоёр урсгал бүхий 5.6 км замыг шинэчлэх ажлыг 2013 оноос хийж эхэлсэн байна. Замын засвар шинэчлэлийн ажлын хүрээнд ус зайлуулах систем, гурван уулзварт гэрлэн дохио, зам дагуу ногоон байгууламж, услалтын системийн ажлыг хийжээ. Түүнчлэн иргэдийн тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, тоосжилтын хэмжээг багасгах, аймгаа цэвэр цэмцгэр байлгах зорилгын хүрээнд гэр хорооллын дундуур 10 км хатуу хучилттай авто зам барих ажил эхлүүлсэн байв. Энэ талаар тус аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн М.Дэлгэрдалай "Бид улсын төсвөөс ямар нэгэн хөрөнгө зарлагүй аймгийнхаа төсвөөр гэр хорооллын дундуур 10 км зам барьж байна. Замын ажил одоогийн байдлаар 90 гаруй хувьтай байгаа. Мөн нийтийн тээврийн үйлчилгээг шийдэхийн тулд орон нутгийнхаа компанитай гэрээ хийж, гурван чиглэлд бага оврын 12 микро автобус иргэдэд үйлчилж эхэлсэн" гэсэн юм. Энэ мэтчилэн үр өгөөжээ өгсөн, хийж бүтээсэн, бүтээж буй ажлууд цөөнгүй ажээ.

### Хүүхдийн баяраа цэцэрлэгт хүрээлэнд тэмдэглэнэ

Зургадугаар сарын 1-нд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр тохионо. Энэ өдрөөр тус аймгийн хүүхэд багачууд шинэ цэцэрлэгт хүрээлэндээ баярлах аж. Учир нь 2014 оноос эхэлсэн Гавшгайчдын талбайг төв цэцэрлэгт хүрээлэн болгох ажил ирэх сарын 1-нд дуусч, нээлтээ хийх юм байна. Энэхүү цэцэрлэгт хүрээлэнд янгир, бар, тэмээ гээд хүүхэд багачуудын анхаарлыг татахуйц нөгөөтэйгүүр өөрийн аймгийн түүхэн онцлогтой холбогдуулан олон хөшөө босгосон байв. Түүнчлэн цэцэрлэгт хүрээлэн нь хиймэл нуур, хүрхрээ, дугуйн зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламж зэргээс бүрдэх аж. 1.8 тэрбум төгрөгийн төсвөөр бүтэж буй уг цэцэрлэгт хүрээлэнгийн ажлыг "Их модун" компани хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 90 гаруй хувьтай байгаа талаар тус компанийн инженер Я.Аваандорж хэлсэн. Цэцэрлэгт хүрээлэн нь нутгийн өнгө үзэмжийг нэмэх, жуулчдыг татах зорилготой төдийгүй нутгийн иргэдэд худалдаа үйлчилгээ эрхлэх боломж олгож буйгаараа онцлогтой.

### 1050 хүүхдийн цэцэрлэг, 1280 хүүхдийн сургууль шинээр ашиглалтад оржээ

Баянхонгор аймагт өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд хийгдсэн онцлох бүтээн байгуулалтын нэг нь сургууль, цэцэрлэгийн барилгын ажил. Тэр дундаа 2-6 настнуудад сургуулийн өмнөх боловсрол олгоно гэдэг хамгийн чухал. Энэ хүрээнд өнгөрсөн хугацаанд л гэхэд аймгийн хэмжээнд 1050 хүүхдийн цэцэрлэг шинээр ашиглалтад оржээ. Одоогоор 250 хүүхдийн багтаамжтай цэцэрлэгийн барилга угсралтын ажил ид хийгдэж байгаа гэнэ. Энэ цэцэрлэг ашиглалтад орвол аймгийн хэмжээнд 1300 хүүхэд цэцэрлэгт хамрагдах боломжтой болж байгаа талаар тус аймгийн Боловсролын газрын дарга Д.Байгалмаа тайлбарласан. Харин ерөнхий боловсролын сургуулийн барилгын хувьд 690 хүүхэд сурах боломжтой сургуулийн барилгын ажил хийгдэж байгаа бөгөөд ашиглалтад орвол нийт 2240 хүүхэд сургуульд хамрагдаж, ерөнхий боловсрол эзэмших юм байна.

### Наадмын талбайг өргөтгөж, 3000 суудалтай болгов

УИХ-ын гишүүн Х.Баттулгын санаачилгаар 2008 оны тавдугаар сард Баянхонгор аймагт анх удаа бага олимпийн бамбарыг буухиалж, дөрвөн жил тутамд уламжлал болгон зохион байгуулж байхаар шийдвэрлэсэн. Уламжлал ёсоор өнгөрсөн жил бага олимп тус аймагт болж, ирсэн зочдыг алмайруулаад амжсан. Тэгвэл тус олимпийг зохион байгуулсан наадмын цэнгэлдэх хүрээлэн нь анх 1970 онд байгуулагдсан түүхтэй аж. Энэхүү цэцэрлэгт хүрээлэнг шинэчлэх ажлыг Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийнхан 2014 онд хийсэн байна. Бүтээн байгуулалт шинэчлэлийн ажил нийт 300 сая төгрөгийн өртгөөр хийгджээ. Уг шинэчлэлийн хүрээнд олон ажил хийгдсэн аж. Тухайлбал, 1500 хүний суудал бүхий цэнгэлдэхийн багтаамжийг өргөтгөн 3000 хүний суудалтай болгожээ. Мөн ашиглалтыг сайжруулахын тулд стандартын хөлбөмбөгийн талбай, гар болон сагсан бөмбөгийн талбай, дөрвөн эгнээ гүйлтийн замыг тавьсан байна.

### 1136 айл орон сууцтай болжээ

Иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэхийн тулд орон сууцжуулах бодлого баримтлан ажиллаж байгаа ажээ. Энэ хүрээнд 2012-2015 онд нийт 1136 айлын орон сууц ашиглалтад орсон байна. Тодруулбал, 2012 онд 409 айлын орон сууц, 2014 онд 349 айлын орон сууц, 2015 оны хагас жилийн байдлаар 378 айлын орон сууц ашиглалтад оржээ. Мөн аймгийн оршин суугчдын ихэнх хувь нь гэр хороололд оршин суудаг тул тэдний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд инженерийн шугам сүлжээний асуудлыг шийдсэн байна. Тухайлбал, гэр хорооллын гадна усан хангамжийн 9.2 км магистрал шугам тавьсан аж. Мөн цэвэрлэх байгууламжийн өргөтгөх ажлыг ч хийжээ. Энэ мэтчилэн тус аймагт хийж бүтээсэн ажил олон байлаа. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд Баянхонгор аймагт нийт 77.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгджээ.

МЭДЭЭЛЭЛ

## МАХН-ынхан өлсгөлөн зарлалаа

Ж.МЯГМАР

МАХН-ынхан төв байрныхаа өмнө өлсгөлөн зарлаж буй. Уг нь тэд Эрх чөлөө, Чингисийн талбайд жагсаал цуглаан, өлсгөлөн зарлахаар хүсэлт гаргасан ч холбогдох байгууллагаас зөвшөөрөл өгөөгүй тул ийнхүү намын байрныхаа өмнө өлсгөлөн зарлаж байгаа юм. Тэд өлсгөлөн зарлаж буй шалтгаанаа "УИХ-ын 2016 оны сонгуульд МАХН-ыг оролцуулахгүй байх бүхий л бусармаг аргыг хэрэглэж байгаа бөгөөд МАХН-ын дарга Н.Энхбаяр, дэд дарга Э.Эрдэнэжамъян нарын зарим нэр дэвшигчдэд хууль хяналтын байгууллагаас хууль зөрчин шаардлагатай бичиг баримтыг санаатайгаар гаргаж өгөхгүй байна. Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгууль нь сонгуулийн хуулийг дордуулсан, луйврын орчинд, олигархиудын гар хөл болсон хууль хяналтын зарим албан тушаалтны хууль бус үйлдлээс хамаарч явагдаж буйг эрс эсэргүүцэн буйгаа мэдэгдэж байна. Засаг төрийн эрх мэдлийн үндэс нь ард түмний хүсэл зориг мөн, засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна, Монгол Улсын иргэн сонгох, сонгогдох эрхтэй, хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг баримтлах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэсэн ардчиллын тулгуур зарчим, үзэл санааг үл тоомсорлон уландаа гишгэж сонгогчдын шийдлээр бус өөрсдийн хүсэл шунал, захиалгад нийцүүлэн сонгуулийн дүнг урьдчилан засварлахаар МАНАН-гийн бүлэглэл эрээ цээргүй явуулга хийж байна. Монголын ардчиллыг хамгаалах "сонгуулийн хувьсгал" хийж, эх орноо хамтдаа өөрчлөх цаг ирлээ. Шударга сонгууль-шударга ардчилсан төрийн эхлэл.

Иймийн учир эхнээсээ хууль бус, хяналтгүй сонгууль явуулахаар төлөвлөсөн, хэт даварсан эрх мэдэлтнүүдтэй эрхээ хамгаалах улс төрийн хатуу тэмцэл хамтдаа явуулцгаая. Дүр эсгэсэн ардчилагчид хуулийн нэр барин хүний эрхийг бүдүүлгээр зөрчиж Монголын ардчиллыг булшиллаа. Тэд ардчилсан улсын хувиар АСЕМ зохион байгуулна гэж олон зуун тэрбум төгрөг хяналтгүй зарцуулж, ядарч зовсон ард түмнээрээ тохуурхаж байна" хэмээн тайлбарлаад байна.

ШАР МЭДЭЭ

## С.Жавхлан гавьяат П.Анужин, Д.Арвин нартай өрсөлдөх нь

Б.ЭРХЭС

Увс аймгийн харьяат, "Хамаг Монгол" төслийн удирдагч, МУГЖ С.Жавхлан УИХ-ын 2012 оны сонгуулиар төрсөн нутагтаа нэр дэвшээд өвдөг шороодсон билээ. Гэсэн ч гавьяат маань бууж өгөөгүй төдийгүй өнгөрсөн хугацаанд урлаг соёлоор монгол тулгатныг нэгтгэх том ажлыг эхлүүлж "Хамаг Монгол" гэх төслийг эхлүүлсэн. Мөн хандивын тоглолт хийж, хогийн цэгт амьдардаг хүүхдүүдийг баярлуулах, зуданд нэрвэгдсэн малчин түмэнд туслах зорилгоор, оюутны ширээнээс хослон дуулж нийтийн дууны урлагт танигдаж байсан Т.Баясгалантай хамтран тоглолт хийж байв. Тэгвэл гавьяат маань өнөө жилийн сонгуулиар АН-д элсч Увс аймагт нэр дэвших, мөн төрсөн нутагтаа бие дааж нэр дэвшинэ гэх яриа дуулдаж байсан ч тэрбээр Баянзүрх дүүргийн 54 дүгээр тойрогт бие даан нэр дэвшихээр болжээ. Уг тойрогт МАН-аас "Монгол тулгатны 100 эрхэм" нэвтрүүлгийн хөтлөгч П.Анужин, АН-аас УИХ-ын гишүүн Д.Арвин нар өрсөлдөж байгаа юм. Урлаг, спортынхон өнөө жил улс төрд олноор хүч үзэж байгаа цуваag үргэлжлүүлсэн эрхэм гавьяатыг сонгох эсэх нь баянзүрхчүүдийн хүсэл таашаал биз ээ. Юутай ч өнөө жилийн сонгуульд Олимпийн аварга Н.Түвшинбаяр, Дархан аварга А.Сүхбат, дуучин Г.Эрдэнэтунгалаг, дуучин Нара, Бэки, С.Жавхлан зэрэг олон ч хүмүүс өрсөлдөж буй юм.

ӨӨР ӨНЦӨГ

## СЕХ МАХН-ынхныг бүртгэж, хууль зөрчих үү

С.НАРАНЧИМЭГ

МАХН-ынхан өнгөрсөн дөрвөн жилд Засгийн газрын малгайд хорогдож, сайдтай, шантааэжтай туг, дарцаг шиг хийсч байв. МАХН-ын эрх ашигт нийцэхгүй л бол "Ерөнхий сайдыг огцруулна", "Засгийн газраас гарна" гэж айлын эрх хүүхэд шиг дураараа аашилж байлаа. Улс төрийн ууган хүчин гэгддэг МАН-ынхан хүртэл угшил нэгт МАХН-ынхантай хамтарч сонгуульд оролцох санал санаачилга гаргасан удаатай. Хоёр намаас ажлын хэсэг гарч, хэд хэдэн асуудалд тохиролцсон байдаг. Гэвч Н.Энхбаяр гэдэг хүний хэмжээ хязгааргүй шуналаас болж, хэлэлцээр амжилтад хүрээгүй. Тэгвэл яг одоо улс төрийн нөхцөл байдал 180 градус эргэчихээд байна. Засгийн газраа шантаажилдаг МАХН-ынхныг Гүйцэтгэх засаглалын тэргүүн гэрээсээ "хөөв". Дээр нь МАН-ын тавьсан саналыг чамлаж байсан МАХН-ынхан өнөөдөр УИХ-ын сонгуульд оролцож чадахгүйдээ тулчихаад өлсгөлөн зарлаад сууж байна. Учир нь тус нам хуульд заасан хуулийн хугацаанд амжиж нэр дэвшигчдээ тодруулаагүй гэх мэдээлэл байна. Нэр дэвшүүлэх нийтлэг журмын 129 дүгээр зүйлд "Нам эвсэл сонгуульд оролцох хүмүүсээ санал авах өдрөөс 37 хоногийн өмнө эхлүүлж, тав хоногийн хугацаанд дуусгана" гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл тавдугаар сарын 23-27-ны нэр дэвшилтийн асуудлыг нэг тийш нь цэгцэлчихсэн байна гэсэн үг. Гэтэл МАХН нэр дэвшигчээ тавдугаар сарын 28-ны шөнийн 04.00 цагт тодруулж дууссан сурагтай. Хэрвээ хуулийн хугацаанд амжаагүй бол СЕХ бүртгэхээс татгалзах хуулийн заалттай. Энэ удаагийн сонгуульд Н.Энхбаяр амжилт үзүүлж, чадахгүйгээ эртнээс мэдсэн учраас "Шударга сонгуулийн төлөө", "Улс төрийн хэлмэгдүүлэлтийг зогсооё", "Ард түмний эрх ашгийн төлөө" зэрэг уриа лоозонтойгоор ард түмнээр өрөвдүүлэх хуучин тактикаа барьж эхлэв. УИХ-ын 2012 оны сонгуульд МАХН чамлахааргүй амжилт гаргасан гэдэгтэй хэн ч маргахгүй. Дөрвөн жилийн настай Н.Энхбаярын ялалт өнөөдөр гудамжны улс төр лүү шилжих хэмжээнд доройтжээ. Нэгэнт хуулийн хугацаандаа амжиж МАХН нэр дэвшигчээ тодруулаагүй болохоор СЕХ бүртгэж, авахгүй байх магадлал өндөртэй. Хэрвээ СЕХ МАХН-ын нэр дэвшигчдийг бүртгэж авбал Сонгуулийн тухай хуулийг зөрчсөн болж таарна. Сонгууль эхлээгүй байхад СЕХ хуулиа зөрчөөд эхэлбэл хэл амны бай болохоос гадна улс төрийн хямралд түлхэх аюултай. Тэгэхээр СЕХ-нд хуулиа дагахаас өөр сонголтгүй болж байна. МАХН улс төрийн өлсгөлөнгөөс айж нэр дэвшигчдийг нь бүртгэвэл СЕХ хуулиа хэрэгжүүлдэггүй "муухай" харагдах нь лавтай.

mminfo.mn Шударга, Шуурхай, Өнцгөй мэдээлэл

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**Харилцах утас, факс: 976-70113551**

**"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын 60 мөр

## АСЕМ-ийн төлөөлөгчид аваад явчих биш дээ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Цаашид АСЕМ-д зориулж иим ч юм хийлээ, тийм ч мөнгө зарцуулллаа, ард түмнийг мартлаа гээд л харлуулж өгнө дөө. Уг нь АСЕМ-ийн зам, ардын зам гэж юу байх вэ дээ. Улаанбаатарт л ганц нэг аятайхан зам нэмэгдэж, чанаржиж, сайжирч л байвал бидэнд хэрэгтэй. АСЕМ-ийн төлөөлөгчид яах вэ, Улаанбаатар ирээд хоёр гуравхан хоног болоод л буцна. Яах вэ дээ, тэр аятайхан замаар яваад, монголчууд чинь бас ч тийм болхи бүдүүлэг нөхдүүд биш байна, зам харгүй нь гайгүй юм гэсэн сэтгэгдэлтэй буцвал бидэнд л хэрэгтэй. Тэд явахдаа бидний барьсан замыг хуулж аваад л явчихав гэж дээ. Бидний хийсэн бүтээсэн эх орондоо л үлдэнэ. Дараа нь ард түмэн бид л тэр замаар зорчино. Тэр харьцуулаад байгаа шиг зам манай Улаанбаатарын гэр хорооллууд болоод бусад газруудад зөндөө л байгаа. Өмнө нь Улаанбаатарын бүх л зам тийм байсан биз дээ. Харин өнгөрсөн хэдэн жилд гайгүй засаад, аятайхан болгочихлоо. Цаашид ч замаа аятайхан болгоод, засаад явна. Хоёр, гуравхан жилийн дотор өргөс авчихсан юм шиг бүгдийг нь гялтайлгаад, толийлгоод, засаад дуусгачихна гэж юу байдаг юм. Тийм болохоор ядаж л пиараа зөв сонгох хэрэгтэй байна шүү дээ. Хэрвээ энэ мэтээр пиар хийх гэж байгаа бол арай өөр өнцгөөс нь хар л даа. Манайхан АСЕМ-д зориулж бүтээн байгуулалт хийж байгаа ч халтуурдсан тохиолдлууд гарсан. Хан-Уулын хуучин байшингуудын зам руу харсан хэсгийнх нь дээврийг будаж янзлаад, нөгөө талыг нь орхичихсон байсан. Түүн шиг АСЕМ-ийн гэгдээд байгаа замаа чанартай, сайн л тавьсан байгаасай билээ. Зочид төлөөлөгчид ирээд явлаа, хэд хоногийн дараагаас хуулраад, ховхроод, эвдрээд байхгүй л бол болно. Харин хэсэг хугацаанд нүүр тахалчихаад, дараа нь бутарчихаар зам хийчихсэн бол ёстой өөрөөр ярих хэрэгтэй. Тийм л биш бол АСЕМ-ийн зам гэж байхгүй. Энд, Улаанбаатарт, Монголд хийж байгаа болгон бидэнд, иргэдэд зориулагдсан л юм шүү дээ. Хэрвээ АСЕМ болохгүй байсан бол ингэж бүтээн байгуулалт хийж, зам харгуйгаа засч янзалж, сайжруулахгүй ч байсан юм бил үү. Мэдээж төлөвлөлтийн дагуу замаа засаад, ажлаа хийгээд л явах байсан байх. Гэхдээ л АСЕМ-ийн буянаар бүтээн байгуулалт илүү эрчимжиж, хурдацтай ч байгаа шүү дээ. Энэ чинь л давуу тал. Тийм болохоор бидэнд хэрэгтэй гээд л бодчих. Түүнээс биш АСЕМ-ийнхан яваад, ард түмнийг явуулахгүй зам ч гэж юу байх вэ дээ.

# ӨНӨӨ ЖИЛИЙН СОНГУУЛИАР “ГАЛ ГАРСАН” ТУЛААН ӨРНҮҮЛЧИХ ӨРСӨЛДӨГЧИД АЛГА

–УИХ–ын сонгуульд нэр дэвшигчдээ улс төрийн намууд эцэслэн батлав–

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Мөн хэний ч санаанд багтамгүй хуваарилалт, нөгөө талаар намын захиас даалгавраар тойргоо сольсон хүмүүс ч цөөнгүй байлаа. УИХ-ын гишүүн Р.Амаржаргал энэ удаагийн нэр дэвшилтээс өөрийн саналаар татгалзаж Орхон аймагт “жийгдсэн” УИХ-ын гишүүн М.Батчимэгийг дэмжиж, боломж олгосон нь улс төрийн шинэ жишиг байсан гэж хэлж болно. Нөгөө талаар Булганы тойргийн төлөө үхэн хатан тэмцэж байсан УИХ-ын гишүүн Ё.Отгонбаяр энэ удаад өнжихөөр шийдсэн нь мөн л сонин мэдээ байв. Эдгээр гишүүдээс гадна С.Оюун, Ц.Дашдорж, Д.Дэмбэрэл, Ж.Батсуурь нарын зургаан гишүүнээс бусад 70 гишүүн эргээд парламентын танхимд тухлахын тулд ирэх сонгуульд хүч үзэхээр болжээ. Түүнчлэн, ирэх сонгуулиар олны санаанд оромгүй нэр дэвшигчдээс гадна сонирхолтой гэж хэлж болохуйц тулаан ч гарах нь тодорхой байгаа. Тухайлбал, УИХ-ын гишүүн Д.Батцогт, С.Бямбацогт нар нэг айлын хүргэчүүл. Гэсэн ч улс төрийн хатуу тоглоом тэднийг шоглож, тэд нэг тойрогт хоёр өөр намаас өрсөлдөхөөр болжээ. Нөгөө талаар ах дүүгийн тангараг тасраад буй гэх төрсөн ах дүүс болох Ш.Батсамбуу, Ш.Сайхансамбуу нар нэг тойрогт өрсөлдөж, ах нь дүүгээ гаргахгүйн тулд улайрч буйг харахад улс төр өс хонзон авах хэрэгсэл болжээ гэдэг нь харагдах аж. Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн гуайн хоёр хүүхэд хоёр өөр намаас нэр дэвшихээр болжээ. Тодруулбал, охин Б.Энхбайгаль АН-аас Төв аймагт нэр дэвшч МАН-ын дарга М.Энхболдтой өрсөлдөх бол, хүү Б.Хүдэр-Ян ТТ эв нэгдлийн эвслээс Хэнтийд хүч үзэх аж. Тэгвэл С.Ганбаатар ч мөн төрсөн дүү С.Гантуяатайгаа хамт их улс төрд өрсөлдөж байна. Мөн Олимпийн аварга Н.Түвшинбаяр Баянхонгор аймагт АН-аас, Олимпийн мөнгөн медальт Х.Цагаанбаатар Дархан-Уул аймагт ТТ эв нэгдлийн эвслээс, Параолимпийн аварга Д.Баатаржав Сэлэнгэ аймагт мөн ТТ эв нэгдлийн эвслээс, Дархан аварга А.Сүхбат Төв аймагт МАН-аас тус тус нэр дэвшихээр болсон юм. Сэтгүүлзүй, урлагийнхан ч энэ цуваа үргэлжлүүлэв. Тухайлбал “Монгол тулгатаны 100 эрхэм” нэвтрүүлгийн хөтлөгч П.Анужин Баянзүрх дүүрэгт МАН-аас, Яруу найрагч Г.МөнхцэцэгГовьсүмбэраймагтМАН-аас, ММ агентлагийн захирал асан, сэтгүүлч М.Оюунчимэг Чингэлтэй дүүрэгт МАН-аас, дуучин Г.Эрдэнэтунгалаг Сэлэнгэ аймагт АН-аас, Төрийн соёрхолт, жүжигчин Ц.Төмөрбаатар МАХН-аас Баянзүрх дүүрэгт тус тус нэр дэвшихээр болсон бол дуучин С.Жавхлан бие дааж Баянзүрх дүүрэгт, дуучин Нара Баянгол дүүрэгт, дуучин Бэки мөн нэр дэвшихээр болсон билээ. Энэ мэтээр бурхан шашны төлөөллөөс эхлээд урлаг, спорт, тэмцэгч, сэтгүүлзүй гээд бүх л нийгмийн төлөөлөл хүч үзсэн үзэх харах зүйлтэй, өрсөлдөөн ч ширүүхэн сонгууль болох нь тодорхой байгаа юм.

Харин улс төрийн намуудын дарга нарын тухайд гэвэл АН-ын дарга З.Энхболд Баянгол дүүргийн 70 дугаар тойрог, МАН-ын дарга М.Энхболд Төв аймгийн 28 дугаар тойрог, МАХН-ын дарга Н.Энхбаяр Сонгинохайрхан дүүргийн 75 дугаар тойрог, ТТ эв нэгдэл эвслийн тэргүүлэгч Г.Уянга Чингэлтэй дүүргийн 66 дугаар тойргийг амлан авчээ. Өнгөрсөн баасан гарагийн байдлаар намууд нэр дэвшигчдээ эцэслэсэн бол өнөөдөр бие даагчдыг бүртгэх ажил дуусна. Ингэснээр УИХ-ын болон НИТХ-ын сонгуульд өрсөлдөгчдийн дунд зөвхөн сурталчилгаандаа анхаарах асуудал үлдэх билээ. Ер нь өнөө жилийн сонгуулиар хоорондоо өрсөлдөж байгаа хүмүүсийг харахад ямар ч ширүүн өрсөлдөөн харагдахгүй байгаа юм. Зарим тохиолдолд хэт давуу улстөрчид эмэгтэйчүүдийг торгууль байдлаар өгсөн, эсвэл хоёр намын тохирооноос болсон уу илт давуу өрсөлдөгчид үнэхээр жулдахаар нэр дэвшигч зоосон асуудал олон байна. Сүхбаатар дүүрэг, Өвөрхангай, Орхон зэрэг ганц нэг аймгийн онцлох тойргуудыг эс тооцвол өнөө жил гал гарсан тулаан аль тойрогт болохгүй гэдэг нь харагдаж байгаа юм. Энэ мэтээр ирэх сонгууль тун ч амтгүй өрсөлдөөнтэй болох дүр зураг эхнээсээ харагдаж эхлэв. Улс төрийн намуудаас нэр дэвшигчдийн жагсаалтыг эцсийн байдлаар уншигч танд хүргэе.

2016 оны УИХ–ын сонгуульд нэр дэвшигчдийн жагсаалт /СЕХ–нд хүргүүлсэн байдлаар/

| Д/д | Аймаг, дүүрэг | Тойрог | МАН | АН | МАХН | ТТ эв нэгдэл эвсэл |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Архангай | 1 тойрог | Г.Тэмүүлэн | Д.Ганхуяг | Ц.Цэдэндамба | |
| | | 2 тойрог | Ё.Баатарбилэг | Н.Батбаяр | Б.Ганцэцэг | |
| | | 3 тойрог | Ж.Мөнхбат | Р.Гончигдорж | Н.Тамир | |
| 2 | Баян-Өлгий | 4 тойрог | Г.Солтан | А.Бакей | | |
| | | 5 тойрог | Х.Баделхан | Х.Ержан | | |
| | | 6 тойрог | А.Тлейхан | Д.Мурат | Д.Чинзориг | |
| 3 | Баянхонгор | 7 тойрог | Г.Занданшатар | Д.Ганбат | А.Одончимэг | |
| | | 8 тойрог | М.Билэгт | Н.Түвшинбаяр | Б.Ууганбаяр | |
| | | 9 тойрог | Л.Элдэв-Очир | Х.Баттулга | А.Батдорж | |
| 4 | Булган | 10 тойрог | Ж.Бат-Эрдэнэ | О.Амартүвшин | Б.Шижирбаатар | |
| 5 | Говь-Алтай | 11 тойрог | Ш.Раднаасэд | О.Амгаланбаатар | Н.Бүргэдаа | |
| 6 | Говьсүмбэр | 12 тойрог | Г.Мөнхцэцэг | Г.Ганбаатар | Д.Батдэлгэр | |
| 7 | Дорноговь | 13 тойрог | Б.Дэлгэрсайхан | З.Алтангэрэл | Б.Батмөнх | |
| 8 | Дорнод | 14 тойрог | Х.Болорчулуун | М.Зоригт | Ж.Энхжаргал | |
| | | 15 тойрог | Н.Номтойбаяр | Б.Мөнхцэцэг | Ш.Ганболд | |
| 9 | Дундговь | 16 тойрог | Б.Амарсанаа | Б.Наранхүү | О.Ганбат | Ц.Нармандах |
| 10 | Завхан | 17 тойрог | Б.Энхболд | Я.Санжмятав | Д.Балдан-Очир | З.Цэрэндулам |
| | | 18 тойрог | Ш.Батсамбуу | Я.Санжмятав | Б.Батхуяг | Ш.Сайхансамбуу |
| 11 | Өвөрхангай | 19 тойрог | Я.Содбаатар | Н.Батцэрэг | Б.Эрдэнэбилэгт | А.Отгонбаатар |
| | | 20 тойрог | Б.Тогтохсүрэн | Ч.Даваабаяр | Ё.Бямбатогтох | |
| | | 21 тойрог | С.Чинзориг | С.Дэмчиг | Ч.Цэндээ | |
| 12 | Өмнөговь | 22 тойрог | Н.Амарзаяа | Д.Бадраа | Д.Эрдэнэ | |
| | | 23 тойрог | Б.Энхболд | Д.Бат-Эрдэнэ | Б.Буджаргал | |
| 13 | Сүхбаатар | 24 тойрог | Ч.Улаан | Ж.Батсуурь | н.Энхбаатар | |
| 14 | Сэлэнгэ | 25 тойрог | Н.Оюундарь | С.Баярцогт | Л.Ганболд | Т.Бат-Эрдэнэ |
| | | 26 тойрог | Ж.Эрдэнэбат | Г.Эрдэнэтунгалаг | Ш.Эрдэнэбат | Д.Баатаржав |
| | | 27 тойрог | С.Бүрэнбат | Д.Эрдэнэбат | А.Энхболд | |
| 15 | Төв | 28 тойрог | М.Энхболд | Б.Энхбайгаль | М.Оюунсайхан | Ц.Баттөр |
| | | 29 тойрог | А.Сүхбат | н.Энхсайхан | Д.Батсайхан | |
| | | 30 тойрог | Н.Энхболд | Д.Доржпүрэв | О.Буяннэмэх | |
| 16 | Увс | 31 тойрог | Б.Чойжилсүрэн | О.Цогтгэрэл | | Я.Цэрэнханд |
| | | 32 тойрог | Н.Цэрэнбат | Н.Алтанхуяг | | |
| | | 33 тойрог | Ч.Хүрэлбаатар | Б.Сүрэнжав | Н.Уламбаяр | |
| 17 | Ховд | 34 тойрог | Ч.Очбадрах | Д.Пүрэвдорж | Б.Дондовбалжир | П.Баатарсүрэн |
| | | 35 тойрог | С.Бямбацогт | Д.Батцогт | Х.Батболд | Б.Туяабадрах |
| | | 36 тойрог | н.Батнасан | Ш.Адьшаа | Ш.Булган | С.Цэрэнчимэд |
| 18 | Хөвсгөл | 37 тойрог | Л.Мөнхбаатар | П.Цагаан | Ч.Чинчулуун | |
| | | 38 тойрог | Ц.Даваасүрэн | Ц.Оюунгэрэл | Б.Санчир | Л.Доржпалам |
| | | 39 тойрог | Л.Энх-Амгалан | Б.Эрдэнэбат | н.Саранхүү | |
| 19 | Хэнтий | 40 тойрог | Б.Бат-Эрдэнэ | М.Хүдэрбаатар | | |
| | | 41 тойрог | Л.Оюун-Эрдэнэ | Б.Гарамгайбаатар | П.Ариунжолоо | Б.Хүдэр-Ян |
| | | 42 тойрог | Д.Гантулга | Ж.Оюунбаатар | Б.Одхүү | Н.Санжаадорж |
| 20 | Дархан-Уул | 43 тойрог | Д.Баттөмөр | М.Сономпил | Ж.Сүхбаатар | Х.Цагаанбаатар |
| | | 44 тойрог | Б.Жавхлан | Н.Мөнхдаш | Л.Мөнхсайхан | Ц.Ивээлт |
| | | 45 тойрог | Д.Хаянхярваа | Р.Бурмаа | Д.Араажав | Н.Мөнхтөр |
| 21 | Орхон | 46 тойрог | О.Содбилэг | Д.Алтанхуяг | Д.Оюунбат | Ц.Нарантуяа |
| | | 47 тойрог | Д.Атармаа | Д.Одхүү | О.Баасанхүү | Ц.Сарантуяа |
| | | 48 тойрог | Д.Дамба-Очир | Б.Мягмарсүрэн | Л.Ариунаа | Ж.Лхагвадорж |
| 22 | Баянзүрх дүүрэг | 49 тойрог | Д.Оюунхорол | Д.Зоригт | С.Жаргал | О.Бум-Ялагч |
| | | 50 тойрог | Ж.Энхбаяр | Б.Болор | Ч.Өлзийсайхан | Х.Хүрэлбаатар |
| | | 51 тойрог | Б.Саранчимэг | Р.Булгамаа | Ц.Цолмон | М.Мөнхцэцэг |
| | | 52 тойрог | Б.Батзориг | Ч.Сайханбилэг | Л.Чулуунбаатар | М.Мөнхзаяа |
| | | 53 тойрог | Ч.Төмөрчулуун | Ж.Батзандан | Д.Эрдэнэцогт | М.Шагдарсүрэн |
| | | 54 тойрог | П.Анужин | Д.Арвин | Ц.Төмөрбаатар | Б.Чулуунбат |
| 23 | Хан-Уул, Багахангай дүүрэг | 55 тойрог | Д.Сарангэрэл | Ж.Ганхуяг | Ц.Оюунбаатар | Д.Энхболд |
| | | 56 тойрог | Ц.Нямдорж | Г.Байгальмаа | Б.Хэрлэн | Х.Амарсайхан |
| | | 57 тойрог | С.Оюунбилэг | Л.Болд | Ц.Лхагвасүрэн | Ц.Өлзийтогтох |
| | | 58 тойрог | Б.Энх-Амгалан | Г.Батхүү | Х.Оюунцэцэг | Б.Одончимэг |
| 24 | Сүхбаатар, Багануур дүүрэг | 59 тойрог | Д.Цогтбаатар | Б.Мэдрээ | Н.Удвал | Ц.Мөнхжин |
| | | 60 тойрог | Ц.Мөнх-Оргил | Х.Тэмүүжин | Л.Сэлэнгэ | А.Лхамдэгэд |
| | | 61 тойрог | Сү.Батболд | М.Батчимэг | И.Энхтүшиг | Б.Энхмаа |
| | | 62 тойрог | Ц.Цогзолмаа | Л.Гантөмөр | Ц.Баярхүү | Н.Наранцэцэг |
| 25 | Чингэлтэй, Налайх дүүрэг | 63 тойрог | Т.Аюурсайхан | С.Дэмбэрэл | А.Даваасүрэн | Х.Батсуурь |
| | | 64 тойрог | М.Оюунчимэг | Г.Баярсайхан | Ц.Эрдэнэчулуун | Ж.Батболд |
| | | 65 тойрог | Ө.Энхтүвшин | Б.Мөнхтуяа | Э.Эрдэнэжамъян | П.Болд |
| | | 66 тойрог | Д.Ганболд | О.Эрдэнэбулган | Ж.Батбаяр | Г.Уянга |
| 26 | Баянгол дүүрэг | 67 тойрог | А.Ундраа | С.Одонтуяа | Б.Тулга | Н.Буянжаргал |
| | | 68 тойрог | Ж.Ганбаатар | Д.Оросоо | Х.Оюунцэцэг | Б.Санжаажав |
| | | 69 тойрог | Л.Амгалан | С.Эрдэнэ | М.Алтантуяа | С.Ренчигпагма |
| | | 70 тойрог | Д.Лүндээжанцан | З.Энхболд | Ч.Амарбаяр | П.Бямбачулуун |
| 27 | Сонгинохайрхан дүүрэг | 71 тойрог | Ц.Гарамжав | Ө.Пүрэвбаатар | Л.Отгонбаяр | Н.Дашзэвэг |
| | | 72 тойрог | Н.Учрал | Л.Эрдэнэчимэг | З.Баянсэлэнгэ | Ц.Эрдэмт |
| | | 73 тойрог | Д.Сумъяабазар | М.Чинболд | Б.Оюунбилэг | Б.Саранцэцэг |
| | | 74 тойрог | Д.Тэрбишдагва | Б.Ургамалцэцэг | Ц.Лхагвасүрэн | М.Баярхүү |
| | | 75 тойрог | Б.Ундармаа | Ш.Түвдэндорж | Н.Энхбаяр | З.Болдбаатар |
| | | 76 тойрог | Х.Нямбаатар | О.Магнай | Г.Бямбасүрэн | |

# МЭДЭЭЛЭЛ

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2016 оны 5 дугаар сарын 30**
Тендер шалгаруулалтын нэр: **"МИАТ" ТӨХК-ийн албан хэрэгцээнд Майкрософтын албан ёсны лицензтэй програм хангамж нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **05/2016-Хд**

МИАТ ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос Майкрософтын албан ёсны лицензтэй дараах програм хангамж–ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Үүнд:
1. Microsoft Windows 10 Pro – 250 ш
2. Office Standard 2016 (Word, Excel, PowerPoint, OneNote, Outlook, Publisher, Office Online) – 180 ш
3. Windows Server 2012 R2 Standard Server Licence – 10 ш
4. Windows Server Device Client Access License (CAL) – 250 ш
5. Microsoft SQL Server Enterprise Core 2 Software License – 2ш

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50,000 төгрөг**, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **2014, 2015 оны аль нэг жилд 400,000,000 /Дөрвөн зуун сая/ төгрөгөөс багагүй**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **400,000,000 /Дөрвөн зуун сая/ төгрөгөөс багагүй**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, тайлбар тодруулга, аудиторын дүгнэлтийн хамт 2014 он, 2015 он**

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жилийн аль нэг жилд 200,000,000 /Хоёр зуун сая/ төгрөгөөс багагүй ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн байна. /2014 он, 2015 он/**

**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:**
Microsoft Volume Licensing – Майкрософт корпорацийн том байгууллагын багц лицензжүүлэлт бүхий "Microsoft Products and Services Agreement" лицензийг нийлүүлэгч нь Майкрософт корпорацийн "Large Account Reseller/Licensing Solutions Provider" албан ёсны эрхтэй байх

Тендерийн хамт 6,996,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2016 оны 6 дугаар сарын 15-ны 10:00 цаг**–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2016 оны 6 дугаар сарын 15-ны 10:30 цаг**-т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.
Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**МИАТ ХК, Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа дахь МИАТ ТӨХК-ийн төв байр, Захиргаа, эрх зүйн хэлтэс 213 тоот**
**Гэрээ хариуцсан мэргэжилтэн Н.Жадамба Утас: 70049852, 99780000**

## AN INVITATION FOR BID

May 30th, 2016
Name of the Project: **For supply of Microsoft software licenses**
IFB No: **05/2016-Хд**

MIAT Mongolian Airlines invites sealed bids from eligible bidders for supply of the following permanent Microsoft software licenses.

1. Microsoft Windows 10 Pro – 250 pcs
2. Office Standard 2016 (Word, Excel, PowerPoint, OneNote, Outlook, Publisher, Office Online) – 180 pcs
3. Windows Server 2012 R2 Standard Server Licence – 10 pcs
4. Windows Server Device Client Access License (CAL) – 250 pcs
5. Microsoft SQL Server Enterprise Core 2 Software License – 2 pcs

Submission of the document shall be in written form/or additional document/ and in order to participate in the bid, parties shall deposit a non-refundable fee of 50,000 /fifty thousand/MNT or in an equivalent amount in a free convertible currencies. The payment can be transferred to the Golomt Bank account number 1102036061 of the MIAT Mongolian Airlines (МИАТ ТӨХК). Bids shall be valid for 45 days from the date of its opening.

Bidders must meet the following financial and experience requirements. Herein:

Sales volume: **Each of year 2014 and 2015, sales volume has to be no less than of 400,000,000 /four hundred million/ MNT.**

Hedge funds and available credit amount: **400,000,000 /Four hundred million/ MNT.**

Submission of audited financial statements of annual figures: **The last 2 years with audited financial statements and explanatory notes have to be certified to the auditor /2014, 2015/**

The average cost of similar work undertaken over the last three years: **In any year in the last 2 years, has to have performed in the amount of no less than 200,000,000 /Two hundred million/ MNT in similar work in accordance with agreement. /2014 and 2015/**

**Official license is required to submit:**
Microsoft Volume Licensing - Microsoft Products and Services Agreement license provider must be an official Microsoft Large Account Reseller/Licensing Solutions Provider (with license).

With the submission, include 6,996,000 /six million nine hundred and ninety six thousand/ MNT with the equivalent to the value of the tender guarantee.

Bidders must submit their documents prior to the date of 10:00 AM, June 15th, 2016 and opening will be held on 10:30 AM, June 15th, 2016 with the presence of the participants wishing to be involved.

Foreign persons have the right to submit a bid.
Domestic privilege shall not be granted.
Interested parties can obtain the bidding documents and other information from the following address.

**Address: Room number #213, MIAT building, Buyant-Ukhaa-10, Khan-Uul district, Ulaanbaatar, Mongolia. Phone: 70049852, 99780000**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2016 оны 5 дугаар сарын 30**
Тендер шалгаруулалтын нэр: **"МИАТ" ТӨХК-ийн албан хэрэгцээнд Оракл корпорацийн програм хангамжийг лицензжүүлэх компанийг сонгон шалгаруулах**
Тендер шалгаруулалтын дугаар: **13/2016-Н**

МИАТ ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос Оракл(Oracle) Корпорацийн програм хангамжийг лицензжүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Үүнд:

1. Oracle Database Enterprise Edition 12c (Хугацаагүй/Perpetual) – 6 processor license
2. Software update license & support – 1 year

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50,000 төгрөг,** эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

**Борлуулалтын хэмжээ:**
2014, 2015 он тус бүрийн борлуулалтын хэмжээ 400,000,000 /дөрвөн зуун сая/ төгрөгөөс багагүй
**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:**
400,000,000 /Дөрвөн зуун сая/ төгрөгөөс багагүй
**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:**
Сүүлийн 2 жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, тайлбар тодруулга, аудиторын дүгнэлтийн хамт 2014 он, 2015 он
**Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:**
Сүүлийн 2 жилийн аль нэг жилд 400,000,000 /Дөрвөн зуун сая/ төгрөгөөс багагүй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна. /2014 он, 2015 он/
**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:**
1. Оракл (Oracle) корпорацийн албан ёсны Gold Partner нийлүүлэгч гэдгийг нотолсон баримтыг ирүүлэх/гэрчилгээ/.
2. MAF /Manufacturing Authorization Form/ буюу Ораклаас тус тендерт оролцохыг зөвшөөрсөн зөвшөөрөл байх/ирүүлэх

Тендерийн хамт 10,352,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2016 оны 6 дугаар сарын 30-ны 10:00 цаг**–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2016 оны 6 дугаар сарын 30-ны 10:30 цаг**-т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.
Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**МИАТ ХК, Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа дахь МИАТ ТӨХК-ийн төв байр, Захиргаа, эрх зүйн хэлтэс 213 тоот**
**Гэрээ хариуцсан мэргэжилтэн Н.Жадамба Утас: 70049852, 99780000**

## AN INVITATION FOR BID

**May 30th, 2016**
Name of the Project: **For supply of Microsoft software licenses**
IFB No: **13/2016-Н**

MIAT Mongolian Airlines invites sealed bids from eligible bidders for supply of the following permanent Microsoft software licenses.

1. 1. Oracle Database Enterprise Edition 12c (Perpetual) – 6 processor license
2. Software update license & support – 1 year

Submission of the document shall be in written form/or additional document/ and in order to participate in the bid, parties shall deposit a non-refundable fee of **50,000** /fifty thousand/MNT or in an equivalent amount in a free convertible currencies. The payment can be transferred to the Golomt Bank account number 1102036061 of the MIAT Mongolian Airlines (МИАТ ТӨХК). Bids shall be valid for 45 days from the date of its opening.

Bidders must meet the following financial and experience requirements. Herein:
**Sales volume: Each of year 2014 and 2015, sales volume has to be no less than of 400,000,000 /four hundred million/ MNT.**

Hedge funds and available credit amount:
**400,000,000 /Four hundred million/ MNT.**

Submission of audited financial statements of annual figures:
**The last 2 years with audited financial statements and explanatory notes have to be certified to the auditor /2014, 2015/**

The average cost of similar work undertaken over the last two years:
In any year in the last 2 years, has to have performed in the amount of no less than 400,000,000 /Four hundred million/ MNT in similar work. /2014 and 2015/

**Official license is required to submit:**
1. Must be a licensed Gold Level Oracle Partner.
2. Must have MAF /Manufacturing Authorization Form/ upon Oracle's acceptance for Tender.

With the submission, include 10,352,000 /Ten million three hundred and fifty two thousand/ MNT with the equivalent to the value of the tender guarantee.

Bidders must submit their documents prior to the date of 10:00 AM, June 30th, 2016 and opening will be held on 10:30 AM, June 30th, 2016 with the presence of the participants wishing to be involved.
Foreign persons have the right to submit a bid.
Domestic privilege shall not be granted.
Interested parties can obtain the bidding documents and other information from the following address.

**Address: Room number #213, MIAT building, Buyant-Ukhaa-10, Khan-Uul district, Ulaanbaatar, Mongolia. Phone: 70049852, 99780000**

УЛСТӨРЧИЙН ХӨРӨГ

# Хэм хэмжээг тогтоогч



> ...Энэ бүхнийг гүйцэлдүүлэхдээ Д.Эрдэнэбат хэзээ ч урьдчилан зарлаж, сүр үзүүлээгүй. Засгийн газар, УИХ-д ард түмний төлөөлөл болон сууж буйн хувьд хийх ёстой ажил хэмээн үзэх нь бий. Эдүгээ Сэлэнгэ аймаг өрхийн болоод жижиг, дунд үйлдвэрлэлээрээ тэргүүлэх болсны цаад талд ч энэ эрхэм ажиллаж байдаг юм. Иймээс та түүнийг нутагтаа очиход нь юу хийх төсөөллөө цаасан дээр буулгачихаад хүлээж байгаарай. Тэр таныг дэмжээд зогсохгүй, бүр цоо шинэ санааг ч хэлээд өгөх байх. Та хоёрт амжилт хүсье...

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

Дондогдоржийн Эрдэнэбат бид хоёр нэг довны хүүхдүүд. Хараагийн гудамжнаа унадаг дугуйгаар уралдаж, гүйдэг матк тоглож, шоглож, шоглуулж явсангүй. Өөрөөр хэлбэл, намайг сургуулийн босго дөнгөж алхан, цагаан толгой, математикийн ном, хэдэн дэвтрээс өөр зүйлгүй шахам ширэн цүнхээ дааж ядахдаа байдгаараа гилжийсэн бяцхан сурагч явахад тэрбээр аравдугаар ангийн том ах байлаа. Гэвч үеийнхээ хөвгүүдтэй гитар үүрэн, хөлбөмбөг өшиглөн, сургуулийн улаан буланд урлагийн үзлэг давтангаа зүггүйтэж явсных нь зах зухаас бол мэднэ ээ. Бас манай гудамжны эмгэчүүд оройн сэрүүнд хашааныхаа гаднах явган сандал дээр бор шувуу адил зээглэж суугаад урдуур хойгуур өнгөрөх охид, хөвгүүдийг ирээдүйд хэн болохыг нь шинжицгээдэгсэн. Тэр дунд нь хичээлдээ явсан ч, тугалаа хариулсан ч унадаг дугуйнаас ер салдаггүй хүүгийн тухай яриа хөвөрч л явах. "Дондогоо багшийн том хүү, их сайн хүн болно шүү. Буянхишиг эмч, Дондогоо багш хоёр гэрийн бараа харах биш. Эрэгтэй хүүхэд атлаа гэрийнхээ хамаг ажлыг энэ хүү л хийж байгаа харагддаг юм" хэмээн ам нийлүүлэн магтацгаахыг нь сонсч өссөн. Миний эмгэн буурал ижий тийн магтан дуулагсдын нэг нь л дээ. Үнэндээ Зүүнхараагийнхан залхуу хойрго нэгнийг үнэн голоосоо үзэн яддаг улс. Том жижиггүй л үүрийн таван жингээр тахиа донгодмогц босч, мал хуй, ногоо цагааныхаа ажлыг амжуулчихаад хичээл, сургуульдаа одоцгоох. Хашаандаа ногоо тарьдаггүй, гахай, шувуу тэжээдэггүй, саалийн үнээгүй айлыг аж ахуй буюу Хэрх тосгон, Жаданов, Чапаев, Калинин, Ленинийн гудамжаас бараг л олохгүй болов уу даа. Тэр хэрээр хараагийнхан бусдаас гуйхааргүй, сайхан амьдарцгаадаг биз ээ.

Д.Эрдэнэбат ч ийм л амьдрал дунд өсч хүн болсон нэгэн. Магадгүй хар багаасаа ямар ч ажлыг хүнд хэцүү, хар бор гэлгүйгээр нугалж ирсний буянд тэр өдий зэрэгтэй яваа ч байж мэднэ. Удам судрыг нь аваад үзэхэд ч тэр муу явах учиргүй хүү. Түүний эцэг Дондогдорж багшийг Хараагийн ард түмэн үе үеэрээ мэднэ. Зарим нь математикийн хичээл заалгаж байсан байлгүй. Шулуун шударга зантай, өөрийн үзэл бодлоосоо хэзээ ч ухарч, няцдаггүй занг хүү Эрдэнэбат нь дуурайсан юм билээ. Сайн хэрэг. Өвгөн багшийн дэргэд шадарлаж, дотоод сэтгэл рүү нь өнгийгөөгүй нэгэн бол чанга, хатуу хүн гэлцдэг л байсан байх. Харин олон жил айл явсан хөршүүд нь, удирдлага дор нь ажиллаж байсан сургуулийн хамт олон нь бусдын сайн сайхны төлөө бүхнээ зориулж ирсэн хүнлэг чанар, нэг хором ч зүгээр суухыг тэвчдэггүй хөдөлмөрч занг нь үгүйлэн дурссаар байдаг юм. Буянхишиг эмч гэж хүний хайлан буй. Шөнө дунд ч хашааных нь хаалгыг нүдээд зогсох нэгнийг төвөгшөөх нь бүү хэл, дугуй төмөр хайрцагтай эм хэрэгслээ бариад л "Танайх чинь аль гудамж билээ" гэсээр гараад ирнэ. Би ч тийн нойрыг нь хугаслуулсан олон арван багачуудын нэг нь. Эдүгээ Дархан хотод ажлаар очсон хэн бүхэн эзэн нь үгүй гэлгүйгээр өвгөн багшийнд саатан хөгшнийх нь амар мэндийг эрэх далимдаа амарч тухлаад явна. Зарим нь зориуд хоног тааруулж очих нь ч бий. Ийм л гэр бүлд Д. Эрдэнэбат өсч торнисон. Үүгээрээ би юуг илэрхийлэх гээд байна вэ гэвэл сайн хүний үр тэрбээр муу хүн байх үндэсгүй билээ. Эгэл жирийн уурхайчнаас төрийг түшилцэх хэмжээнд очтолоо өсч дэвжинэ гэдэг хэн хүнд тохиох хувь тавилан мөн үү. Харин Эрдэнэбатад ийм хувь тохиосон. Тэр эгэл боргил амьдралыг сайн мэднэ. Байх байхгүйн зовлон, хийж бүтээхийн хүсэлд автаж яваа хүн ямар ч тохиолдолд хана мөргөөд зогсдогийн зовлонг бие сэтгэлээрээ туулсан бизнесмэн. Тэрбээр нэг л өглөө уурхайн дарга, нэртэй бизнесмэн, тулхтай улстөрч, Монгол Улсын сайд болчихоогүй. Бас хэн нэгэн албан тушаалтны цүнхийг тэврэч гүйгээгүй. Бусдын халаас руу мөнгө хаяж улс төрөөс зүүгдээгүй. Үзэл бодол, шударга зан, урваж шарвадаггүй зангараг нь түүнийг улс төрд хөтөлсөн. Бүр тод зам мөртэйгөөр. Тэр бас шууд УИХ-ын гишүүн болчихоогүй. Дүүргийн Засаг дарга гэх улс төрийн албан тушаалаас улстөрчийн гараагаа эхэлснийг хэн хүнгүй мэдэх юм хойно. Багануур дүүргийн Засаг даргаар хоёр удаа, НИТХ-д гурван удаа сонгогдож, 12 жил багануурчуудтай "ноцолдож" байж УИХ-д нэр дэвших эрхийг олж авсан юм. Д.Эрдэнэбат УИХ-ын ээлжит сонгуульд гурван удаа дэвшиж, 2012 онд УИХ-д сонгогдон, УИХ дахь Олонхийн бүлгийн дарга, Аж үйлдвэрийн сайдаар ажиллаж байгаа гэхээр улс төрд яавч шинэ хүн биш. Харин Монголын парламент гэх их айлын босгоор алхаад удаагүй ч, гүйлгээ ухаан, бүхнийг залж чаддаг, араасаа дагуулдаг зангаргаараа хойморт нь уригдаж чадсан улстөрч. Эдүгээ АН гэлтгүй улс төрийн бүхий л хүчин эгзэгтэй цаг үед Д.Эрдэнэбат нь юу гэж дуугарахыг хүлээх болж. Заримдаа тэрслүү гэмээр зан нь, зангараг нь цөөнхийн бүлгийг дороо хавчиганахаас цаашгүй болгож орхих нь бий. Ардчилсан намыг өнгөрсөн УИХ-ын ээлжит сонгуульд тэр л авч гарч, төрийн эрх барих цулбуурыг намдаа атгуулсан. Намынхаа гал тогоонд эзэн сууж байх үедээ ч мань хүн Ардчилсан намын их нүүдэл хааш чиглэвэл тогтвортойгоор намар, өвлийн гурван сарыг зовлон үгүй туулахыг тооцоолж, шийдэл нь ямар байвал зохистойг бүрэн утгаар нь хэрэгжүүлж чадсан генсек. Ардчилсан нам түүнийг Ерөнхий нарийн бичгийн даргаар ажилласан он жилүүдэд улс төрийн түүхэн шийдвэрүүдээ гаргаж, тэр бүхэн нь амжилтад хүрсэн байдаг. МҮДН-ын угшилтай хэмээгддэг ч сүүлийн найман жилийн турш фракциудын тэнцвэртэй байдлыг ямагт хадгалж ирсэн гавьяатай. Д.Эрдэнэбат гэх энэ эрхмийн талаар шулуухан хэлэхэд, тэрбээр улс төрийн бүхий л албан тушаалын хэм хэмжээ ямар байхыг өөрийнхөөрөө тогтоожээ. Улсын стандарт, хэмжил зүйн товчоо шиг ажиллаж. Намын ерөнхий нарийн бичгийн даргын хувьд ч тэр, Аж үйлдвэрийн сайдын тухайд ч ялгаагүй. Түүнийг гүйцэж сэтгэх, учрыг нь олж хужрыг нь тунгаах генсек АН-ын түүхэнд одоогоор алга байна. Энэ мэтчилэн нутгийнхаа түшээг магтах шалтгаан надад олон буй. Хэн нэгнийг буланд шахан фракцилсан тухай дуулаагүй. Тийм жудаггүй үйлдлийг хийх ч хүн биш. Миний мэдэхийн, Д. Эрдэнэбатыг УИХ-ын олонхийн бүлгийн даргаар ажилласан хоёр жилд Ерөнхий сайд нь огцролгүй, Засгийн газар нь солигдоогүй юмдаг. Ямар ч тохиолдолд тогоо тогоондоо эзэн байхыг намынхаа, журмынхаа нөхдөд сануулж байхыг нь нэг бус удаа сонсч байлаа. Авлига, албан тушаалын наймаанаас хол явсаар ирсэн, хол ч явах биз. Монголын төр түүний эл чанарыг үнэлэн Аж үйлдвэрийн сайдаар томилсон биз ээ. Аж үйлдвэрийн салбар гэдэг чухамдаа айл өрхөөр бол амьжиргааных нь эх үүсвэр юм. Энэ салбарын ажил үйлс өөдрөг байхын хэрээр Монгол Улсын эдийн засаг тогтвортой байж, иргэдийнх нь зоо нуруу тэнэгэр байх учиртай билээ. Д. Эрдэнэбат сайдын тухайд боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, хөдөө аж ахуй шиг бодлого чиглэл нь тодорхой , үйл ажиллагаа нь цэгцэрч тогтсон яам хүлээж аваагүй. Шинэ цагийн Монгол Улсын хөгжлийн бааз суурь нь аж үйлдвэрийн салбар байна гэж АН тодорхойлоод зогсохгүй үүнийг аль нэг яам бөөрөндөө наасан байдлаар авч явах бус биеийг нь даалгах ёстой гэсэн байр сууриас Аж үйлдвэрийн яам байгуулах шийдвэрийг Засгийн газар гаргаж, УИХ дэмжиж баталснаар асуудал шийдэгдсэн ч цаасан дээр "байгуулсугай" гэх өгүүлбэрээс цаашгүй салбарын хувь заяаг хэнд атгуулах вэ гэдэг чухамдаа яам байгуулахаас илүү төвөг учруулсан гэнэ билээ. Тэгтэл УИХ-ын гишүүн Р.Амаржаргал "Ерөнхий сайдад өгч чадах миний зөвлөгөөгөөр бол..." гэж байгаад Д.Эрдэнэбатын нэрийг санал болгосон байдаг юм. Харин эдүгээ энэ хүний хичээл зүтгэлээр Монгол Улс байгалийн баялгаа хэрхэн боловсруулах арга замыг тодорхойлсны дээр хүнд, хөнгөн үйлдвэрийн салбар төрийн нэгдсэн бодлоготой болсон, хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлсэн гээд 60 жилийн түүхтэй яам лугаа болжээ, жил зургаан сарын хугацаанд. Түүнчлэн дэлхийн хэмжээний боловсруулах үйлдвэрүүдийн зураг төсөл ч бэлэн, хаана хаана байгуулагдах нь ч тодорхой болсон байх жишээтэй. Ингэж л тэрбээр дэлхийн хөгжлөөс хоцрогдоод байсан аж үйлдвэрийн салбарыг зөв бодлого, зөв менежментийн хүчээр бусдын гаргасан жимээр өгсөх бус амдан хөгжихийн эхлэлийг тавьж, Монгол Улсыг импортолдог бус үйлдвэрлэдэг орон болгохын төлөө цаг наргүй ажиллаж явна. Ардчилсан намын лидерүүдийн нэг хэмээн түмэнд хүлээн зөвшөөрөгдсөн тэрбээр төрөлх нутаг усныхаа хөгжил дэвшлийн түүчээ нь болохоор УИХ-ын ээлжит сонгуульд нэр дэвшиж байна. Тиймээс нутгийн түмэн минь, гараа дэлгээд тосоод ав. Дашрамд хэлэхэд, Д. Эрдэнэбат бусад шиг ам гардаггүй зантай. Тийм юм хийнэ, ингэж хөгжүүлнэ хэмээн ярихгүй ч байж мэднэ. Тэгсэн мөртөө дотоод сэтгэлдээ нутаг усныхаа хөгжил цэцэглэлтэд өөрийн хувь нэмрийг ямар байдлаар оруулах ёстойг, төрийн бодлогод алийг нь тусгавал илүү үр дүнд хүрэхийг нь хэдийнэ дотор хүнтэйгээ хэлэлцэж, заримынх нь гаргалгааг олчихсон явж байдаг юм. Аж үйлдвэрийн сайдаар томилогдсон даруйд концессийн гэрээгээр олон олон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаагаас магадгүй зарим нь танай суманд хэрэгжээд эхэлсэн ч байж мэднэ. Ямартай ч хамгийн түрүүнд Мандал сумыг төв замтай холбох 15.5 км замын асуудлыг шийдсэн нь эдүгээ ашиглалтад орж, миний нутгийнхан хар замаар сүнгэнэцгээх болсон. Мөн Хүдэр-Ерөө чиглэлийн 104.5, Түшиг-Цагааннуур чиглэлд 145 км автозам тавиулсан бол Төмөртэй- Хандгайт чиглэлийн 32.5 км төмөр замыг барьж ашиглалтад оруулжээ. Үүнээс гадна 1000 тонны багтаамж бүхий зоорь Мандал суманд баригдаж байгаа юм билээ. Ирэх намар гэхэд шинэ ургацын төмс, хүнсний ногоог хүлээж авах биз. Үүнээс гадна ТОСК-ийн үйл ажиллагааны хүрээнд 124 айлын орон сууц ашиглалтад оруулж. Сэлэнгийн бусад суманд шинэ шинэ орон сууц бүхий хотхон, хорооллууд эхнээсээ ашиглалтад орсон харагдсан. Орхон, Орхон туул суманд цөм сүргийн бүтцийг сэргээх бодлого барин,шаардагдах төсвийг улсын төсөвт суулгасныг нь би хувьдаа санаж байна. Нөгөөтэйгүүр, сүүлийн жилүүдэд сэлэнгэчүүдийн гэлтгүй газар тариалангийн бүс нутгуудад тариаланч, малчин хоёрын тариалангийн талбай, малын бэлчээрээ булаалдан ил далд тэмцэлдэн асуудал үүсгээд байгаа газрыг шийдэх арга замыг тэр хуульчилж өгөхөөр хуулийн төсөл боловсруулах бодолтой байгааг нь энд онцлоход таатай байна.

Энэ бүхнийг гүйцэлдүүлэхдээ Д.Эрдэнэбат хэзээ ч урьдчилан зарлаж, сүр үзүүлээгүй. Засгийн газар, УИХ-д ард түмний төлөөлөл болон сууж буйн хувьд хийх ёстой ажил хэмээн үзэх нь бий. Эдүгээ Сэлэнгэ аймаг өрхийн болоод жижиг, дунд үйлдвэрлэлээрээ тэргүүлэх болсны цаад талд ч энэ эрхэм ажиллаж байдаг юм. Иймээс та түүнийг нутагтаа очиход нь юу хийх төсөөллөө цаасан дээр буулгачихаад хүлээж байгаарай. Тэр таныг дэмжээд зогсохгүй, бүр цоо шинэ санааг ч хэлээд өгөх байх. Та хоёрт амжилт хүсье.



# ДЭЛХИЙ

ОНЦЛОХ МЭДЭЭ




# БАРАК ОБАМАГИЙН ТҮҮХЭН АЙЛЧЛАЛ

Б.ДАВАА

АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамагийн бүрэн эрхийн хугацаа энэ оны сүүлээр дуусна. Тэрбээр бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө АНУ-ын Ерөнхийлөгчийн хувиар Вьетнам, Японд “сүүлчийн” түүхэн айлчлалаа хийгээд эх орон руугаа мордлоо. Дэлхийн II дайнаас хойш 70 жилийн дараа Цагаан ордны төрийн тэргүүн Вьетнам, Японы Хирошима хотноо анх удаагаа айлчилсан нь олон улсын анхаарлыг татаж байв. Тиймдээ ч, тус улсын Ази руу чиглэсэн гадаад бодлогын илрэл хэмээн нэрлэгдэж байсан юм. Барак Обама энэ сарын 27-ны өдрийн орой хувийн нисдэг тэргээрээ Хирошимад газардаж, Энхтайвны дурсгалын цэцэрлэгт хүрээлэнд цаг орчим саатсан байна. Мөн Энхтайвны дурсгалын музей буюу цөмийн бөмбөгдөлтөд өртөгсдийн дурсгалын музейд “Бид дайны гашуун зовлонг туулсан. Энхтайван, цөмийн зэвсэггүй амар амгалан дэлхийг эрэлхийлэх болно” хэмээн мэдэгджээ. “1945 оны наймдугаар сарын 6-ны өглөө болсон тэр аймшигт дурсамж хэзээ ч арилахгүй”. Энэ үгийг Барак Обама уригдан ирсэн 100 гаруй хохирогчдийн өмнө хэлжээ. Мөн тэрбээр цөмийн зэвсгийн давуу болон сул талыг тэмдэглэхээс илүүтэйгээр “Дайны үед аль аль тал хохирол амссан” гэдгийг дахин дахин онцолж байсныг орон нутгийн мэдээллийн сайтууд онцолж байна. Японд айлчлахын өмнө Б.Обама Вьетнамд айлчилсан юм. Тэнд тэрбээр Вьетнамын эсрэг тавьсан зэвсгийн бүх хоригоо цуцалсан байна. АНУ 2014 онд тус улсын эсрэг тавьсан зэвсгийн зарим хоригоо цуцалсан байдаг ч, Вьетнам эдүгээг хүртэл нэг ч зэвсэг тус улсаас худалдаж аваагүй аж. Өмнөд Хятадын тэнгист бүлэг арлын эзэмших эрхийн асуудлаар Вьетнам Хятадтай маргаантай байдаг. Гэсэн ч, дэд бүтэц, хүнсний бүтээгдэхүүний импорт зэргээр эдийн засаг нь Хятадаас хамааралтай байдаг. Ямартай ч, Ерөнхийлөгч Обама Ханой хотноо 2300 гаруй оюутан залуусын өмнө хийсэн мэдэгдэлдээ Вьетнамын дайны үеэр “Гурван сая вьетнамын цэрэг, иргэд, АНУ-ын 58315 иргэн амиа алдсан” гэж өгүүлжээ. Түүнчлэн, хоёр улс дайны гашуун сургамжийг хэзээ ч мартаж болохгүй хэмээн онцолжээ. Ерөнхийлөгчийн энэ удаагийн айлчлал нэрийн дор нуугдсан нэг сэдэв бий. Тэр нь цөмийн бөмбөгдөлтийн улмаас тааруу харилцаатай байдаг дайсагнасан талууд эвлэрч нэгдэх ёстой гэсэн мессэжийг ард түмэнд хүргэх байв. Вьетнамд тус улсын Ерөнхийлөгч Чан Дай Куангтай хамтран хийсэн хэвлэлийн бага хурлын үеэр “Харилцан ашигтай, нэг нэгийгээ хүндэтгэж харилцвал хоёр улсын харилцаа сэргэх бүрэн боломжтой” гэдгийг онцолсон бол Хирошимад хийсэн айлчлалынхаа үеэр “Япон, АНУ хоёр улс эвсээд зогсохгүй нөхөрлөлийн харилцаагаа улам хөгжүүлэх хэрэгтэй” гэж тэрбээр мэдэгджээ. Барак Обама эдүгээг хүртэл Украин болон Сирийн нөхцөл байдалд цэргийн оролцооноос аль болох зайлсхийж ирсэн. Гэвч эрх барьж буй Бүгд найрамдах нам түүнийг сул дорой хэмээн шүүмжилж байсан удаатай. 1955 онд эхэлсэн Вьетнамын дайнд АНУ албан ёсоор 1964 онд орж, 1973 оны сүүлчээр орхиж байжээ. Энэ хугацаанд америкчууд Вьетнамын нутаг дэвсгэрт 6727084 тонн бөмбөг хаясан байдаг ажээ. Харин дэлхийн II дайны үед Японы Хирошимад “Литтл бой” гэх нэртэй цөмийн бөмбөгийг Америкийн цэргийнхэн хаяж, 200 гаруй мянган хүн амиа алдсан байдаг. Бүрэн эрхийн нь хугацаа дуусахад багахан хугацаа үлдээд буй Барак Обама Америкийн цэргүүдийн бөмбөгдөлтийн улмаас ийнхүү хохирол амссан Азийн хоёр улсад айлчилж, дайны гашуун сургамжийг мартагнаж, эвлэлдэн нэгдэх хэрэгтэй гэсэн мессэжийг энэ удаагийн “сүүлчийн” түүхэн айлчлалаараа өгсөн юм.

> ...Ерөнхийлөгчийн энэ удаагийн айлчлал нэрийн дор нуугдсан нэг сэдэв бий. Тэр нь цөмийн бөмбөгдөлтийн улмаас тааруу харилцаатай байдаг дайсагнасан талууд эвлэрч нэгдэх ёстой гэсэн мессэжийг ард түмэнд хүргэх байв...

ДУУЛГАХ СОНИН

## Жонни Депп эхнэрээ зоддог байжээ

Холливудын хамгийн сайхан хосуудын нэг Жонни Депп, Амбер Хёрд нар хуримнаасаа хойш ердөө жил гаруйхан хугацааны дараа салалтаа зарласан билээ. Улмаар Лос-Анжелес хотын шүүх эдүгээ 52 настай жүжигчин Жонни Деппд гэр бүл салах хуулийн хугацаанд эхнэр Амбер Хёрдтай холбоо тогтоохыг хориглох шийдвэрийг гаргажээ. Нөхрөөсөө 20 насаар дүү жүжигчин бүсгүй энэ долоо хоногт хөх няц болсон нүүртэй шүүхийн байранд очиж, нөхөртөө зодуулсан тухайгаа хэлж, салах өргөдлөө өгсний зэрэгцээ тэтгэмж шаардсан байна. Гэрлэснээсээ хойш Депп бүсгүйг удаа дараа зодож байсныг гэрчилж, зургаа хүртэл шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ хавсаргажээ. Хёрд шүүхэд “Гэрлэсэн цагаасаа хойш Жонни Депп намайг үг хэлээрээ ч, бие махбодиороо ч байнга дарамталж байсан” гээд цаашид ч зодож магадгүйг учирласан байна. Нөхрийнх нь хувьд сүүлийн үед ааш зан нь итгэхийн аргагүй хувирч, согтууруулах ундаа, хар тамхи ч хэрэглэх болсныг мөн тэрбээр гэрчилжээ. Шүүх бүсгүйн нэхэмжлэл болоод 40 хуудас бүхий нотлох баримтад үндэслэн Жонни Деппийг жүжигчин бүсгүйд 91 метрээс ойртож болохгүй гэх шийдвэрийг гаргасан байна. Мөн эл хэргийг ирэх сард дахин хэлэлцэхээр болжээ. Депп, Хёрд нар өнгөрсөн жилийн хоёрдугаар сард гэрлэсэн юм. Жүжигчин бүсгүйн хувьд экс нөхрөөсөө амьдарч буй байр болон “Range Rover” маркийн машин, хайртай нохойгоо нэхэмжилж байгаа гэнэ. Хосууд Деппийн ээжийг нас барснаас хоёр хоногийн дараа буюу энэ сарын 22-ны өдрөөс эхлэн тусдаа амьдарч эхэлжээ.


## ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2016-05-26 өдөр
**Тендер шалгаруулалтын нэр:** Баянцагаан багт автомашины гарц барих /мал түүхий эдийн нэгдсэн зах/
**Тендер шалгаруулалтын дугаар:** OP-79/2016

**Орхон аймгийн Засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Баянцагаан багт автомашины гарц барих /мал түүхий эдийн нэгдсэн зах/-ын ажил хийх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.**

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.meps.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын (www.e-procurement.mn) дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 (тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогчид тавих шаардлага:
Үүнд:
**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жил буюу 2014, 2015 оны борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх
**Санхүүгийн тайлан:** 2014, 2015 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх
**Тусгай зөвшөөрөл:** Зам Тээврийн Яамны ЗГ 3.7.2.2 – Туннель, газар доогуур нүхэн гарам барих, засах
**Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй байх

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн [1%] тэнцэх хэмжээний цахим тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 06 дугаар сарын 27-ний өдрийн 14 цаг 00 минутаас өмнө цахим худалдан авах систем (www.meps.gov.mn) хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 06 дугаар сарын 27-ний өдрийн 14 цаг 30 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцохгүй.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

Орхон ЗДТГазар, ХАААлба
Утас:70358570

## ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2016 оны 05 дугаар сарын 27-ний өдөр
**Тендер шалгаруулалтын нэр:** 10-р хороолол 6/0.4 кв-ийн 2*630 кВа чадалтай хаалттай дэд өртөө шугамыг орон нутгийн өмчид авах
**Тендер шалгаруулалтын дугаар:** OP-167/2016

**Орхон аймгийн ЗДТГ эрх бүхий тендерт оролцогчдоос 10-р хороолол 6/0.4 кв-ийн 2*630 кВа чадалтай хаалттай дэд өртөө шугамыг орон нутгийн өмчид авах тухай ЦАХИМ тендер ирүүлэхийг урьж байна.**

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.meps.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

**Тендерт оролцогчид тавих шаардлага:**
**Үүнд:**
**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх
**Санхүүгийн тайлан:** 2014, 2015 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтын хамт ирүүлэх
**Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Санал болгож буй үнийн дүнгийн 50%-аас багагүй байх

Тендерт оролцогч нь санал болгож буй үнийн дүнгийн 80 хувьтай тэнцэх хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээл авах боломжтой байх

Тендерийг 2016 оны 06-р сарын 29-ны өдрийн 14 цаг 00 минутаас өмнө www.meps.gov.mn хаягаар цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 05-р сарын 29-ны 14 цаг 30 минутад нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхтэй.**
**Дотоодын давуу эрх тооцохгүй.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны алба**
**Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө**
**Утас:70358570**

# МЭДЭЭЛЭЛ

## ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдөр
**Тендер шалгаруулалтын нэр:** БОЭТөвд нэн хэрэгцээт тоног төхөөрөмж авах /Центрифуг, Хүчил шүлтийн аппарат, Хагалгааны ор, Хагалгааны гэрэл 2ш, Хүүхдийн сэхээн амьдруулах нэг орны иж бүрэн тоног төхөөрөмж, Амьсгалын аппарат, Мэс заслын багажны ширээ, Электрокоагулятор/
**Тендер шалгаруулалтын дугаар:** OP-58/2016

**Орхон аймгийн ЗДТГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос БОЭТөвд нэн хэрэгцээт тоног төхөөрөмж авах /Центрифуг, Хүчил шүлтийн аппарат, Хагалгааны ор, Хагалгааны гэрэл 2ш, Хүүхдийн сэхээн амьдруулах нэг орны иж бүрэн тоног төхөөрөмж, Амьсгалын аппарат, Мэс заслын багажны ширээ, Электрокоагулятор/ нийлүүлэх тухай ЦАХИМ тендер ирүүлэхийг урьж байна.**

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.meps.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

**Тендерт оролцогчид тавих шаардлага:**
**Үүнд:**
**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жил буюу 2014, 2015 оны борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх
**Тусгай зөвшөөрөл:** Эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх, худалдах
**Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Сүүлийн 2 жил буюу 2014, 2015 оны аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй, үнийн дүнтэй ижил төстэй тоног төхөөрөмж нийлүүлж байсан туршлагатай байх

Тендерт оролцогч нь Санал болгож буй үнийн дүнгийн 1 хувьтай тэнцэх төгрөгийн дүнтэй тендерийн баталгааг цахимаар гаргаж ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 06-р сарын 27-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө www.meps.gov.mn хаягаар цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 06-р сарын 27-ны 10 цаг 30 минутад нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны алба**
**Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө**
**Утас:70358570**







## ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдөр
**Тендер шалгаруулалтын нэр:** БОЭТ-д ходоодны уян дуран нийлүүлэх
**Тендер шалгаруулалтын дугаар:** OP-152/2016

**Орхон аймгийн ЗДТГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос БОЭТ-д ходоодны уян дуран нийлүүлэх тухай ЦАХИМ тендер ирүүлэхийг урьж байна.**

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.meps.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

**Тендерт оролцогчид тавих шаардлага:**
**Үүнд:**
**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жил буюу 2014, 2015 оны борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
**Тусгай зөвшөөрөл:** Шаардлагатай.
Эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх, худалдах
**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх
**Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил буюу 2014, 2015 оны аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй, үнийн дүнтэй ижил төстэй тоног төхөөрөмж нийлүүлж байсан туршлагатай байх

Тендерт оролцогч нь Санал болгож буй үнийн дүнгийн 1 хувьтай тэнцэх төгрөгийн дүнтэй тендерийн баталгааг цахимаар гаргаж ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 06-р сарын 27-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө www.meps.gov.mn хаягаар цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 06-р сарын 27-ны 10 цаг 30 минутад нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхтэй.**
**Дотоодын давуу эрх тооцохгүй.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны алба**
**Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө**
**Утас:70358570**

# ЗАВСАРЛАГА


# KING TOWER
PENTHOUSE & APARTMENT

## FORBES AWARDS-ЫН “ШИЛДЭГ ОРОН СУУЦ”-наас СОНГОЛТ ХИЙЖ, 19-119 САЯЫН БОДИТ ХӨНГӨЛӨЛТИЙГ ЭДЛЭЭРЭЙ



Deluxe Marshall Village хотхоны тансаг зэрэглэлийн **“Luxury King Tower Apartment”** нь таны нэр хүндийн баталгаа бөгөөд үеэс үед өвлөгдөн үлдэх, үнэ цэнэ нь улам өсөх үл хөдлөх хөрөнгө юм. Дэлхийн санхүүгийн №1 Forbes сэтгүүлээс Монголын үл хөдлөх хөрөнгийн шилдэгийг шалгаруулах **FORBES AWARDS**-ын **“ШИЛДЭГ ОРОН СУУЦ”** цомыг “King Tower Apartment” хүртэж, энэхүү нэр хүндтэй шагналын эзнээр тодорсон **Монголын анхдагч** боллоо.

MONGOLIA Forbes
MONGOLIAN PROPERTY AWARDS
ШИЛДЭГ ОРОН СУУЦ

**19-119 сая төгрөгийн бодит хөнгөлөлт эдлэх боломж:** Та амьдралын үнэ цэнэтэй хором мөч бүрийг тайван, тав тухтай өнгөрүүлэх үл хөдлөх хөрөнгөө **“Luxury King Tower Apartment”-ын Crystal, Diamond, Duplex болон Penthouse** загвараас сонгож, **19-119 сая төгрөгийн хөнгөлөлтийг** урьдчилгаа төлбөрөөс хамааран бодитоор эдлэх боломжийг танд олгож байна.

TDB ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК | ХААН БАНК | ГОЛОМТ БАНК | ТӨРИЙН БАНК

**Засгийн газраас хэрэгжүүлж буй 8% зээлийг 7 хоногт шуурхай шийдвэрлэх:** Та Crystal ангилалын **80мкв** хүртэлх талбайтай **2-3 өрөө орон сууцнаас** сонгосноор бидэнтэй хамтран ажилладаг Хаан банк, Худалдаа Хөгжлийн банк, Төрийн банк, Голомт банкны VIP салбаруудаар үйлчлүүлэн, **ипотекийн 8% зээлээ 7 хоногийн дотор шуурхай** шийдүүлэх боломжтой.






**БИД ЧАНАР, ТАВ ТУХЫГ ЭРХЭМЛЭЖ ДЭЛХИЙН БРЭНДЭЭР LUXURY KING TOWER APARTMENT-ЫГ ЦОГЦЛООВ**

VEKA — ГЕРМАНЫ ВАКУМ ЦОНХ
ter Hürne unique as life itself — ГЕРМАНЫ ПАРКЕТАН ШАЛ
Miele — ГЕРМАНЫ ЦАХИЛГААН ХЭРЭГСЭЛ
ThyssenKrupp — ГЕРМАНЫ ЦАХИЛГААН ШАТ
Panasonic — ЯПОНЫ ЦАХИЛГААНЫ ТОНОГЛОЛ
THE BOLD LOOK OF KOHLER — АНУ-ЫН УГААЛГЫН ӨРӨӨНИЙ ТОНОГЛОЛ
LG Hausys — СОЛОНГОСЫН ЭКО ХАНЫН ЦААС
PORCELANOSA — ИСПАНИЙН САНТЕХНИКИЙН ТОНОГЛОЛ

facebook.com/DeluxeMarshallVillage
www.kingtower.mn, www.marshallvillage.mn
Холбоо барих утас: 91918226, 99997063, 88113067
Хаяг: Их тэнгэрийн амруу явах замд, Маршалын гүүрний хойд талд